



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/128/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn</p>
----------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа	14
4.3 Албан шаардлага	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovia@audit.gov.mn

2022.02.25 № 73.

танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙХАН- ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА С.БОЛОРЖАРГАЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

0012020849

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,541,854.05	141,094,854.05
35	БАРАА МАТЕРИАЛ	10,541,854.05	141,094,854.05
354	Хангамжийн материал	10,541,854.05	43,594,854.05
35410	Бичиг хэргийн материал	841,175.00	2,132,775.00
35420	Аж ахуйн материал	9,700,679.05	41,462,079.05
35600	Мал амьтад	-	97,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,284,481,980.77	2,998,214,191.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,284,481,980.77	2,998,214,191.97
392	Биет хөрөнгө	1,268,409,310.41	2,982,072,771.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,353,126,730.64	3,050,922,890.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	(305,011,268.14)	(352,357,170.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	354,278,130.00	304,778,130.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(182,872,906.90)	(117,102,891.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	68,746,883.00	104,363,729.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,168,358.53)	(27,215,567.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,723,266.00	30,723,266.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,731,643.80)	(14,972,947.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,681,521.86)	(66,666.72)
393	Биет бус хөрөнгө	16,072,670.36	16,141,420.29
39301	Програм хангамж	1,960,000.00	1,960,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,351,329.64)	(1,282,579.71)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,464,000.00	15,464,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	1,295,023,834.82	3,139,309,046.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,162,290.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,162,290.00
413	Өглөг	-	1,162,290.00
4136	Бусад өглөг	-	1,162,290.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,162,290.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,295,023,834.82	3,138,146,756.02
51	Засгийн газрын хувь оролцоо	1,295,023,834.82	3,138,146,756.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	429,704,441.09	429,704,441.09
51101	Өмч: - төрийн	429,704,441.09	429,704,441.09
512	Хуримтлагдсан үр дүн	647,997,397.16	2,491,120,318.36
51210	Өмнөх үеийн үр дүн	647,997,397.16	647,997,397.16
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,843,122,921.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	217,321,996.57	217,321,996.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,295,023,834.82	3,139,309,046.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	691,769,098.20	2,458,382,508.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	270,677,708.20	2,029,926,923.34
120	Нийтлэг татварын бус орлого	270,677,708.20	2,029,926,923.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	270,677,708.20	2,029,926,923.34
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	270,677,708.20	2,029,926,923.34

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	421,091,390.00	428,455,585.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,867,961.00	74,934,385.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	16,188,470.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,789,611.00	40,336,120.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,078,350.00	18,409,795.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	372,223,429.00	353,521,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	372,223,429.00	353,521,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	541,320,915.66	591,309,586.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	541,320,915.66	591,309,586.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	513,221,392.22	580,074,599.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,576,452.15	222,576,019.62
210101	Үндсэн цалин	181,347,655.15	159,607,860.57
210102	Нэмэгдэл	25,143,600.00	52,861,314.05
210104	Урамшуулал	-	10,106,845.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,921,006.41	28,859,811.58
210201	Тэтгэврийн даатгал	18,298,939.67	20,013,027.10
210202	Тэтгэмжийн даатгал	2,062,300.00	2,280,370.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,763,300.00	1,763,097.50
210204	Ажилгүйдлийн даатгал	434,207.00	435,475.86
210205	Эрүүл мэндийн даатгал	4,362,259.74	4,367,841.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,608,079.00	28,183,912.00
210301	Гэрэл, цахилгаан	2,111,030.00	1,864,328.00
210302	Түлш, халаалт	18,497,049.00	20,659,644.00
210303	Цэвэр, бохир ус	-	5,659,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,997,060.00	68,257,966.00
210401	Бичиг хэрэг	1,893,500.00	2,619,600.00
210402	Тээвэр, шатахуун	25,181,760.00	16,431,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,334,000.00	2,244,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	174,000.00	7,845,608.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,413,800.00	38,507,838.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	-	609,040.00
2105	Нормативт зардал	-	7,643,380.00
210502	Хоол, хүнс	-	7,643,380.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,588,000.00	2,512,960.00
210604	Урсгал засвар	13,543,000.00	2,512,960.00
2107	Томилолт, зочны зардал	6,594,000.00	7,815,000.00
210702	Дотоод албан томилолт	6,594,000.00	7,815,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,126,189.00	3,038,786.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,545,302.00	1,636,150.00
210803	Даатгалын үйлчилгээ	357,000.00	327,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	292,160.00	239,840.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	131,000.00	131,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	932,727.00	464,796.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,810,605.66	211,186,764.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,421,230.00	55,259,285.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	144,669,375.66	155,927,479.58

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,099,523.44	11,234,986.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,727,500.00	7,281,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,275,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	740,000.00	3,006,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,372,023.44	3,953,186.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,372,023.44	3,953,186.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	150,448,182.54	1,867,072,921.76
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	412,083.92	23,950,000.56
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	412,083.92	23,950,000.56
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(412,083.92)	(23,950,000.56)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	150,036,098.62	1,843,122,921.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	421,091,390.00	428,455,585.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	421,091,390.00	428,455,585.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,867,961.00	74,934,385.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	16,188,470.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,789,611.00	40,336,120.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,078,350.00	18,409,795.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	372,223,429.00	353,521,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	372,223,429.00	353,521,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	401,591,390.00	412,983,485.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	401,591,390.00	412,983,485.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	373,491,866.56	401,748,498.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,476,452.15	222,670,122.75
210101	Үндсэн цалин	181,247,655.15	159,701,963.70
210102	Нэмэгдэл	25,143,600.00	52,861,314.05
210104	Урамшуулал	-	10,106,845.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,921,006.41	28,765,708.45
210201	Тэтгэврийн даатгал	18,298,939.67	19,918,923.97
210202	Тэтгэмжийн даатгал	2,062,300.00	2,280,370.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,763,300.00	1,763,097.50
210204	Ажилгүйдлийн даатгал	434,207.00	435,475.86
210205	Эрүүл мэндийн даатгал	4,362,259.74	4,367,841.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,608,079.00	28,183,912.00
210301	Гэрэл, цахилгаан	2,111,030.00	1,864,328.00
210302	Түлш, халаалт	18,497,049.00	20,659,644.00
210303	Цэвэр, бохир ус	-	5,659,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,216,710.00	32,070,048.00
210401	Бичиг хэрэг	2,840,750.00	3,776,700.00

210402	Тээвэр, шатахуун	22,962,980.00	14,249,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,334,000.00	2,244,000.00
210404	Ном, хэвлэл	-	90,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	215,000.00	8,880,348.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,863,980.00	2,829,400.00
2105	Нормативт зардал	-	1,200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,352,000.00	2,513,290.00
210604	Урсгал засвар	17,307,000.00	2,513,290.00
2107	Томилолт, зочны зардал	6,594,000.00	7,815,000.00
210702	Дотоод албан томилолт	6,594,000.00	7,815,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,281,969.00	6,074,870.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,701,082.00	4,672,234.00
210803	Даатгалын үйлчилгээ	357,000.00	327,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	292,160.00	239,840.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	131,000.00	131,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	932,727.00	464,796.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,041,650.00	72,455,547.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,321,650.00	72,455,547.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,099,523.44	11,234,986.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,727,500.00	7,281,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	4,275,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	740,000.00	3,006,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,372,023.44	3,953,186.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,372,023.44	3,953,186.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19,500,000.00</u>	<u>15,472,100.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	15,472,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	15,472,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	15,472,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	15,472,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(15,472,100.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн / төгрөгөөр /
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	429,704,441.1	217,321,996.6	497,961,298.5	1,144,987,736.2
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	429,704,441.1	217,321,996.6	497,961,298.5	1,144,987,736.2
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	150,036,098.6	150,036,098.6
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,704,441.1	217,321,996.6	647,997,397.2	1,295,023,834.8

D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	429,704,441.1	217,321,996.6	647,997,397.2	1,295,023,834.8
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	429,704,441.1	217,321,996.6	647,997,397.2	1,295,023,834.8
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	429,704,441.1	217,321,996.6	647,997,397.2	1,295,023,834.8
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,843,122,921.2	1,843,122,921.2
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	429,704,441.1	217,321,996.6	2,491,120,318.4	3,138,146,756.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	353,521,200.00	350,793,477.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	353,521,200.00	350,793,477.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346,946,200.00	344,218,477.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,757,500.00	222,670,122.75
210101	Үндсэн цалин	162,515,300.00	159,701,963.70
210102	Нэмэгдэл	52,079,500.00	52,861,314.05
210104	Урамшуулал	9,162,700.00	10,106,845.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	29,173,800.00	28,765,708.45
210201	Тэтгэврийн даатгал	20,285,700.00	19,918,923.97
210202	Тэтгэмжийн даатгал	2,220,800.00	2,280,370.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,833,100.00	1,763,097.50
210204	Ажилгүйдлийн даатгал	438,900.00	435,475.86
210205	Эрүүл мэндийн даатгал	4,395,300.00	4,367,841.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,209,800.00	22,523,972.00
210301	Гэрэл, цахилгаан	2,550,000.00	1,864,328.00
210302	Түлш, халаалт	20,659,800.00	20,659,644.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,033,200.00	29,878,748.00
210401	Бичиг хэрэг	3,252,600.00	3,251,700.00
210402	Тээвэр, шатахуун	11,053,600.00	11,053,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,384,900.00	2,244,000.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	90,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,883,000.00	8,880,348.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,359,100.00	4,359,100.00
2105	Нормативт зардал	1,200,000.00	1,200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,409,300.00	7,390,290.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,895,300.00	4,877,000.00
210604	Урсгал засвар	2,514,000.00	2,513,290.00
2107	Томилолт, зочны зардал	7,815,000.00	7,815,000.00
210702	Дотоод албан томилолт	7,815,000.00	7,815,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,895,600.00	1,522,636.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,000.00	120,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	327,000.00	327,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	312,800.00	239,840.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	131,000.00	131,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00
210807	Газрын төлбөр	764,800.00	464,796.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,452,000.00	22,452,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,452,000.00	22,452,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,575,000.00	6,575,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,575,000.00	6,575,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,275,000.00	4,275,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	2,300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	353,521,200.00	353,521,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	353,521,200.00	353,521,200.00
122005	Орон нутгийн төсвөөс	353,521,200.00	353,521,200.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,727,722.80
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	I НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,708,921.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,708,921.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,002,121.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,659,940.00
210303	Цэвэр, бохир ус	5,659,940.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,721,000.00
210401	Бичиг хэрэг	525,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,196,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,552,234.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,552,234.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,068,947.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,068,947.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	706,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	706,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	706,800.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,225,464.00

213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	1,225,464.00
ИЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		74,934,385.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,934,385.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	16,188,470.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,336,120.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,409,795.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Т.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 18-ны өдрийн 01/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо “Хүмүүнлэг ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, шуурхай, чанартай хүргэж, төрийн албаны зорилт, чиг үүргийг үр ашигтай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдсэн. Хяналт, шалгалтаар албан томилолтын журмыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 591,309.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,913.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,139.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,844,285.3 мянган төгрөгөөр буюу 2.4 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	-	-	-
Бараа материал	10,541.9	141,094.9	130,553.0
Үндсэн хөрөнгө	1,284,481.9	2,998,214.2	1,713,732.3
Нийт хөрөнгө	1,295,023.8	3,139,309.1	1,844,285.3
Өр төлбөр	-	1,162.3	1,162.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,295,023.8	3,138,146.8	1,843,123.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,295,023.8	3,139,309.1	1,844,285.3

Бараа материал дансны үлдэгдэл 141,094.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 130,553.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 60,501.5 мянган төгрөгийн, хандив тусламжаар 52,496.3 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 99,293.1 мянган төгрөгийн нийт 212,290.7 мянган төгрөгийн бараа материалын өсөлт нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 130,553.0 мянган төгрөг болж өмнөх оноос өссөн нь сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 97,500.0 мянган төгрөгийн төмөр сүрэг малыг шилжүүлэн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд хандиваар 1,862,933.5 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 15,472.1 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 1,866.7 төгрөгийн хөрөнгийг зохих дансанд бүртгэж, 299,696.7 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,139,309.1 мянган төгрөг болж 1,844,285.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 353,521.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 353,521.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг дээрх дүнгээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 353,521.2 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 353,521.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 99.2 хувийг зарцуулж, 2,727.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 350,796.1 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, шуудан холбооны зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 40,336.1 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 16,188.5 мянган төгрөг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 18,409.8 мянган төгрөг, нийт 74,934.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 3,721.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 4,552.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 59,068.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 706.8 мянган

төгрөг, байр ашиглалтын зардалд 5,659.9 мянган төгрөг, нийт 73,002.1 мянган төгрөгийг зарцуулж, 1,225.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,612,758.1 мянган төгрөгийн гүүрний барилга, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8,057.6 мянган төгрөгийн худаг, 19,600.0 мянган төгрөгийн хогийн цэгийн тохижилт, зах зээл бэлчээрийн удирдлага төслөөс 58,139.0 мянган төгрөгийн худаг, 22,894.1 мянган төгрөгийн мал угаалгын ванн орлогдож авсан. Уг хөрөнгүүдийн худалдан авах ажиллагааг дээд шатны байгууллага зохион байгуулан худалдан авч шилжүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтэд байгалийн гамшигт үзэгдэлтэй холбоотой малчдад туслах 21,125.5 мянган төгрөгийн хандив орж ирснээс 18,584.5 мянган төгрөгийг гамшигт нэрвэгдсэн малчдад хандив, шатахууны зардалд 2,541.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Цар тахалтай холбоотой 20,253.0 мянган төгрөгийн хандив орж ирснээс 4,455.0 мянган төгрөгөөр ковид илрүүлэх тест, 15,798.0 мянган төгрөгийг сумын онцгой комиссын хяналтын постын шатахуун, хоол хүнс, хамгаалах хэрэгсэл зэрэгт зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 20 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд нийт 428,455.6 мянган төгрөгийн 139 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулснаас 27 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд 11 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүйд өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16,646.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 13,025.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,621.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бусад бараа үйлчилгээний 12,931.0 мянган төгрөгийн зардлыг тээвэр шатахууны зардалд тайлагнасан.
2. Үндсэн цалингийн зардлаас 94.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад нийт 13,025.4 мянган төгрөгийн залруулга хийсэн.

4.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Түлш халаалтын зардлаас бусад байгууллагын 684.8 мянган төгрөгийн халаалтын зардал төлсөн..
2. Тайлант хугацаанд 27 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн.
3. ЭБАТ-ын болон нууцын нэмэгдлийн хувийг аймгийн Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 10-ны А/89 дугаар захирамжинд заасан тогтоосон хэмжээнээс 2,936.2 хэтрүүлэн олгосон.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Тайлант хугацаанд 27 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн.							1			
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Бусад бараа үйлчилгээний зардлыг тээвэр шатахууны зардалд тайлагнасан.			1	12,931.0						
2	Үндсэн цалингийн зардлаас НДШ төлсөн.			1	94.4						

3	Түлш халаалтын зардлаас бусад байгууллагын халаалтын зардал төлсөн.							1	684.8		
4	ЭБАТ-ын болон нууцын нэмэгдлийн хувийг аймгийн Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 10-ны А/89 дугаар захирамжид заасан хэмжээнээс хэтрүүлэн олгосон.							1	2,936.2		
	Нийт зөрчлийн дүн	5	16,646.4	2	13,025.4			2	3,621.0		